

**БНХАУ-ЫН ЯДУУРЛААС ГАРСАН ТУРШЛАГА БА МОНГОЛ
УЛСЫН ЯДУУРЛЫН ӨНӨӨГИЙН ДҮР ТӨРХ, СУРГАМЖ
(GUIZHOU-GUIYANG ХОТЫН ЖИШЭЭН ДЭЭР)**

*А.Батцэцэг**

***Abstract:** The Government of the People's Republic of China, in line with party, political and socio-economic policies to reduce poverty and alleviate poverty, has allocated special funds to the government to improve infrastructure and social services. Our main goal is to increase the participation of the poor in regional development by investing in education, health and employment in poor areas to meet the basic needs of local life and economic development. In June 2019, I got acquainted with the work and development of the People's Republic of China on "Combating Poverty and Poverty Alleviation" and building a prosperous society by 2020, and studied poverty in several cities, towns, villages and ruins. How to reduce poverty in line with the unified state policy based on the specifics of the region and unique weather conditions, the work done within the framework of social responsibility of the enterprises, schools, kindergartens and associations operating in order to get rid of poverty and the measures taken against poverty methods have been studied.*

***Key words:** Poverty, Social transition, Social development, quality of life, China*

Удиртгал

БНХАУ-ын Засгийн газар ядуурлыг бууруулах, ядуурлаас ангижрах бодлогыг нам, улс төр, нийгэм эдийн засгийн бодлоготой уялдуулан алсын хараатай, цогц, хүн төвтэй, ард түмний амьдралд түшиглэсэн ядуурлаас гарах бодлогод тусгай зориулалтын хөрөнгө мөнгийг засгийн газраас гаргаж дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг сайжруулж ялангуяа орон нутгийн ахуй амьдралын наад захын хэрэгцээг хангах мөн эдийн засгийг хөгжүүлэхийн хамт ядуу бүс нутгийн боловсрол, эрүүл мэнд, ажлын байр зэрэгт хөрөнгө оруулалт хийж ядуу хүмүүсийн идэвхитэй байдлыг сайжруулах бүс нутгийн хөгжилд ядуу хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэхийг гол зорилгоо болгон ажилласаар байна. Миний бие 2019 оны 06 сард БНХАУ-ын "Ядууралтай тэмцэх, ядуурлаас ангижрах", 2020 он гэхэд чинээлэг нийгмийг цогцлоох, ядуурлаас бүрэн ангижрах зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажил, бүтээн байгуулалттай танилцаж туршлага судласан бөгөөд хэд хэдэн хот, гацаа, тосгон, балгасуудад ядуурлаас ангижрахын

* ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

тулд үйл ажиллагаа эрхэлж буй үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагууд, сургууль, цэцэрлэг, нийгэмлэгүүдийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, ядуурлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүс нутгийн онцлог болон байгаль цаг агаарын давтагдашгүй хүчин зүйлүүддээ тулгуурлан төрийн нэгдсэн бодлоготой уялдуулж хэрхэн яаж ядуурлыг бууруулсан арга барилтай танилцаж судалсан болно.

1.Хятад улс ядуурлыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

БНХАУ-ын GuiZhou мужийн ядуурлаас гарсан туршлага, GuiYang хотын жишээн дээр:

Амжиргаанаас доогуур орлоготой иргэдээ чинээлэг түвшинд аваачихын тулд 2020 он гэхэд Хятад улс ядуу иргэнгүй болох зорилт тавьж, Хятадын төрийн бодлого хийж хэрэгжүүлж буй ажил бүхэлдээ ядууралтай тэмцэхэд чиглэгдэж, энэ зорилт нь биелэхэд тун ойрхон байна хэмээн GuiZhou мужийн засгийн ордны ядуурлыг бууруулах хэсгийг ахлан ажиллаж буй 郑娟/ZhengJuan/ хэлснийг сонслоо. GuiZhou муж Хятад улсдаа ядуурал харьцангуй их, байгалийн тогтолцоо, эрсдэлт хүчин зүйлүүд давамгайлсан, газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд төдийлөн тохиромжтой бус, төрөөс нэгдсэн бодлогоор нүүлгэн шилжүүлж өрхийн аж ахуй эрхлүүлж, аялал жуулчлалаар гол болгосон муж юм. GuiZhou мужийн Дотоодын нийт бүтээгдэхүүн өнгөрсөн таван жилийн хугацаанд 1.48 их наяд юань буюу 9.1 хувиар өсчээ. 17 гацаа мөн 1100000 иргэнээ ядуурлаас бүрэн ангижруулсан байна. 2018 оны байдлаар 19210000 орчим жуулчин Хятадын GuiZhou мужид жуулчилсан бөгөөд аялал жуулчлалын орлого 11.7 тэрбум юаньд хүрчээ. Хот суурин газарт 66 сая гаруй ажлын байрыг шинээр бий болгожээ. Мөн GuiZhou мужын хувьд импорт болон экспортын хэмжээг тогтвортой нэмэгдүүлнэ гэсэн зорилтыг тавин ажиллаж байна. Иргэн бүрийг баян чинээлэг болгоно гэсэн Хятадын үндэсний стратеги дэлхийн хөгжиж буй бусад улс оронд ч эерэг жишээ болж байгаа талаар албаны хүмүүс ч мэдээлэл өгөв. 1978-2018 оны хооронд Хятадын нэг хүнд оногдох дундаж орлого 18 дахин нэмэгдсэн бөгөөд хоногт 1.9 ам долларын орлоготой амьдарч буй хүн амын тооноос үзвэл 1981 онд 88.3 хувь байсан хэт ядуурлын түвшин 2013 онд 1.9 хувь болтлоо буурч, 850 сая хүн ядуурлаас гарсан бол 2018 онд нэгээс доош хувь руу орох төлөвтэй байна гэж тайланд тэмдэглэсэн байна².

1.1 Хятад улс ядуурлыг бууруулахад хэрэгжүүлсэн бодлогын хувьсал, өөрчлөлтүүд

XX зууны 90-д оны дунд үеэс БНХАУ засгийн газар ядуурлаас гарах төрийн бодлогыг хэрэгжүүлснээс хойш БНХАУ-ын Сангийн яам төрийн өмчийг бие хүнд харьцуулах бодлогоор өөрчилж татварын бодлогод шилжүүлж хөрөнгийн хуваарлалтыг нэг чиглэлийн зохион байгуулалттайгаар ажиллуулах болсон

² Шижин Пин-ний орчин үеийн Хятадын онцлогтой социализмын үзэл санаа, 2019

3. Эдгээр нэг чиглэлийн бодлого нь салбар бүрээр мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулахад тус дэм болж нэг чиглэл нь зөвхөн тухайн чиглэлийн төлбөрийг хариуцах хэлбэрт оруулсанаар дээш шатнаас доод шат хүртэлх нэг чиглэлийн хөрөнгийн урсгалыг бий болгож доод шатны засаг захиргаа төсөл хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан ядуу иргэдэд зориулж төр засгийн зааж өгсөн чиглэлийн дагуу төсөл хэрэгжүүлэх хөрөнгө мөнгийг нь олгон төсөл хэрэгжүүлэх замаар ядуурлаас гарах үйл ажиллагааг өрнүүлж эхэлсэн.

Энэхүү аргачлал нь БНХАУ-ын өөрийн улсын онцлогт нийцүүлсэн ядууралтай тэмцэх шинэ хэлбэр юм. Энэ төслийн хүрээнд 1994 оноос өмнө ядууралтай тэмцэх эдийн засгийн эх үүсвэрийг зээл олгох хэлбэрээр хэрэгжүүлж байсан бол 1994 оноос хойш БНХАУ Намын Төв хорооны тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэлэг тэтгэвэр олгох бус хувь хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн байдаг бол 2000 оноос хойш ядуурлаас гаргахын тулд ядуурлаас гарах хөрөнгө оруулалтыг олон салбарт оруулж, салбар бүрт хамтран оролцож цогцоор нь шийдвэрлэх арга хэмжээг авч байна⁴. Ядуурлаас гарах олон төрлийн төслийг хэрэгжүүлсэнээр борооны дараах мөөг мэт төсөлүүд хэрэгжиж үр дүнгээ өгсөн бөгөөд одоогийн байдалаар БНХАУ нь ядууралтай тэмцэх нэгдсэн боловсронгуй системтэй болж ядуурлаас богино хугацаанд олон тооны иргэнээ ядуурлаас ангижруулж байна. Үүнд: Боловсролын ядууралтай тэмцэх төсөл, эрүүл мэндийн чиглэлийн ядууралтай тэмцэх төсөл, соёлын ядууралтай тэмцэх төсөл, шинжлэх ухаан технологийн аргачилалаар ядууралтай тэмцэх төсөл, аж үйлдвэрийн аргаар ядууралтай тэмцэх төсөл, экологийн ядууралтай тэмцэх төсөл, эмэгтэйчүүдийн оролцоотой ядууралтай тэмцэх төсөл, хүүхдийн оролцоотой ядууралтай тэмцэх төсөл зэрэг чиглэл чиглэлээр цогцоор нь тэмцэх арга хэмжээг авах болсон. 2004 онд ядуу өрхийг оновчтой тодорхойлж ядууралтай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлсэнээр ядууралтай зөв оновчтой тэмцэх арга хэмжээг авсан бөгөөд 2014 онд БНХАУ-ын төв хорооны “Ядуурлыг зөв тогтоох, ядуу хүнд тусламжийг зөв олгох ба зөв зохион байгуулалт хийх” төрийн бодлогын шаардлагын дагуу ядууралтай тэмцэхэд объектийг зөв сонгож, төслийг зөв хэрэгжүүлэх, хөрөнгийг зөв хувиарлах, ядуу айл өрх бүрт ядууралтай тэмцэх арга хэмжээг зөв авч хариуцах эзэнтэй болгосон⁵.

Ядууралтай тэмцэх төсөл хэрэгжүүлэхэд ядуурлаас гаргах санхүү эдийн засгийн эх үүсвэрийг бий болгож, төсөлд хөрөнгө оруулалт хийхэд өөрчлөлт хийх зорилго нь юу байх тухай? Ядууралтай тэмцэх төсөлийг хэрэгжүүлэх явцад ямар асуудал үүсч болох мөн ямар хүндрэл үүсч болох тухай? Эдгээр асуудлыг судлах нь ядууралтай тэмцэх чухал шийдэл байсан юм. Ядууралтай тэмцэх төслийг хэрэгжүүлэх хэв маяг, түүний үр дүнгийн талаар Хятадын олон судлаачид судласан. Эдгээр судлаачдын үндсэн судалгааны чиглэл нь ядууралтай тэмцэх төсөлд оруулах хөрөнгө, төсөл хэрэгжүүлэх болон хэрэгжүүлсэн үр дүнгийн

³ Poverty reduction and social transation. A.Battsetseg ,2019

⁴ China Daily, 2005

⁵ Poverty reduction and social transation. A.Battsetseg, 2019

талаар ихэвчилэн судалсан бөгөөд эдгээр төслийг макро түвшинд судалбал салбар бүрийн засаг захиргааны түвшинд ядууралтай тэмцэх төслийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас харахад тухайн төслийн логикийн уялдаа холбоо, төсөл хэрэгжиж буй явцад гарсан үр дагавар нь төрийн бодлоготой нийцэхгүй байх ч асуудууд гарч байсан хэмээн олон судлаач үзэл бодлоо илэрхийлсэн байдаг.

1.2 Хятад улсын ядууралтай тэмцэж буй ажлын уялдаа ба туршлагыг судлах нь:

Туршлага судлах явцад Хятад дахь ядуурлын төвлөрөлтийг хоёр ангилан авч үзсэн болно: Байгал-цаг агаарын ба Нийгэм-эдийн засгийн гэж. Эхнийхийн хувьд асуудлууд нь байгалийн тогтоц болон цаг ууртай холбоотой бөгөөд ядуусын ихэнх нь явж очиход бэрх алслагдмал газар болон ууланд амьдардаг байна. Цаг агаарын хувьд зүүн-хойд нутаг нь хүйтэн цаг агаарын онцлогтой бол баруун-хойд нутаг нь ган гачигтай ихтэй, төвийн болон өмнөд нутаг нь чийглэг их байх жишээтэй. GuiYang хотын хувьд маш чийглэг уур амьсгалтай, уулархаг, бороо хур элбэгтэй муж юм. Ядуусын түгээмэл орлогын эх үүсвэр нь хүнсний төрөл бүрийн ногооны аж ахуй бөгөөд тухайн аж ахуй эрхлэгч нь хоршоотой нягтран ажиллах ба хоршоо нь ногоочноос авсан ногоог шууд зах зээлд борлуулах гүүр болдог байна.

Хятад улсын ядууралтай тэмцэж буй бодлого GuiZhou мужид хэрхэн биелэлээ олов?

Ядууралтай тэмцэж буй ажлын уялдаа ба туршлагаас харахад:

1. **БНХАУ бол намын удирдлага:** Батласан журмын дагуу намын ажилтан бүр 3-5 ядуу өрхийг халамжлах ёстой, үүний зэрэгцээ удирдах албан тушаалтны зүгээс нийгмийн халамж үзүүлэх ёстой байдаг.
2. **Ядууст туслах аж үйлдвэрлэл:** Нийгмийн халамжийн мөнгөний оронд төрөөс үр, үрсэлгээ, жижиг зээл, мэдээлэл-технологийн үйлчилгээ үзүүлж, цөөн тооны мал өгөх, шагнал зэрэг олгодог. Хүн амын дунд ургамал ногоо тарьжургуулах, гэрийн амьтан өсгөж үржүүлэх, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх талаар сургалт явуулдаг. Санхүүгийн дүрэм болон зах зээлийн эрсдэлд онцгой анхаарал тавьдаг бөгөөд ядуу хүн амыг хөдөлгөөнтэй байж, өөр бүс нутаг руу нүүн шилжихэд бэлэн байхад сургадаг. Амьдрахад илүү тохиромжтой ашиглагдахгүй болсон үйлдвэрийн байрыг сэргээн засварлаж барих талаар семинар, курс явуулдаг аж.
3. **Нэмэлт дадалд сургах:** Ядуу хүн амын дунд дэвшилт технологийн төхөөрөмж дээр ажиллах курс сургалт явуулдаг.
4. **Дэд бүтцийг сайжруулах:** Зах зээлд ойртуулах.
5. **Хөдөөгийн ядуу хүн амд туслах хоршоодыг хөгжүүлэх:** Ядуус орон нутгийн салбарын чиглэлүүдийг хоршооллын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн тусламжаар хөгжүүлэхэд оролцож болдог. Тухайлбал,

хүнсний ногооны аж ахуй, мал амьтаны ферм, засварын газар, эсвэл мод боловсруулах цех, оёдол, гар урлал, жижиг үйлдвэрлэл байгуулж болдог.

6. **Нийгмийн баталгаатай тусламж:** Энэ хэлбэрийн тусламжид эрх баригчидаас ядууст үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ, боловсрол, орон сууцны хангамж болон улс төрийн шийдвэрт тусгасан бусад хэлбэр хамрагддаг байна⁶.

Хятад дахь ядуурлын шугамаар нэг хүнд өдөрт 6,33 юань ногддог бөгөөд энэ мөнгө нь 2018 оны 11-р сарын байдлаар нэг ам. доллартай буюу 6.21 юаньтай тэнцэж байна. Дэлхийн стандартаар бол өдөрт 1,9 ам. долларт хүрэхгүй хүнс тэжээлтэй байгаа хүнийг ядууд тооцдог⁷. Хятад улс 1986 онд Төрийн Зөвлөлийнхөө дэргэд “Ядуурлыг бууруулах агентлаг” Агентлаг байгуулсан бөгөөд энэ хугацаанд ядуурлыг бууруулах урт хугацааны бодлогыг хэрэгжүүлж тав, таван жилийн хугацаатай нарийвчилсан төлөвлөгөөгөө баталдаг байна. Хятад улс сүүлийн 40 жилийн хугацаанд нийтдээ 89 сая иргэнээ ядуурлаас гаргажээ. Зөвхөн сүүлийн таван жилд /2012-2017 он/-д 69 сая иргэнийг ядуурлаас гаргасан байна. Илүү нарийвчилбал, жилд ойролцоогоор 13 сая, өдөрт 35 мянган иргэн чинээлэг дундаж давхрагын эгнээд шилжиж байгаа аж. Өнөөдрийн байдлаар Хятадад 30 сая гаруй иргэн ядуу амьдарч байгаа бөгөөд ирэх хоёр жилд эдгээр иргэдийг дундаж давхарга руу шилжүүлэх зорилгын төлөө хүчээ нэгтгэн зүтгэж байна⁸.

Ядуурлаас ангижрах бодлогын хүрээнд газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор газар авах боломж нээгдсэн төдийгүй Хятадын ард иргэд эзэмшлийн газартаа тариалалт, мал аж ахуйг хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргаж, тогтмол орлогын эх үүсвэртэй болгох зорилготой юм байна. Тогтмол орлоготой болсноор ядуурлаас ангижраад эргээд ядуу амьдрал руу орохгүй гэсэн тооцоололтой. Мөн ядууралтай бүс нутгийг нарийвчлан тогтоож, тухайн бүс нутгийн давуу тал, онцлогт нь тулгуурласан эдийн засгийг тэтгэх, хүн ардын орлогыг нэмэх, ядуурлыг бууруулах тусгай бодлогыг хэрэгжүүлж байгаа аж. Хамгийн түрүүнд, тухайн муж, тосгонд ямар хүмүүс ядуу амьдарч байгааг тогтоож, нэгдсэн системд оруулж түүнд чиглэсэн бодлого боловсруулж, хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг бүх талаар дэмжин ажилладаг аж. Мужийн дарга нарт өгсөн үүрэг даалгавар биелж байгаа эсэхэд хяналт тавьж, хугацаандаа биелээгүй бол сануулга өгч, цаашлаад зарим тосгоны намын үүрийн дарга нарын ажлыг иргэдээр дүгнүүлж, муу оноо авсан даргад нарыг ажлаас нь чөлөөлөх, намын албан тушаалыг нь хураан авах хүртэл арга хэмжээ авдаг байна⁹.

Ядуу амьдарч байгаа иргэдэд сар бүр бэлэн мөнгөний тэтгэмж олгохыг чухалчилдаггүй бөгөөд яруурлыг бууруулахдаа ядуу иргэдийг зөвхөн тэтгэх биш, иргэдээ нээн хөгжүүлэх бодлого баримталж байна. Энэ нь тэтгэмж өгөхөөс

⁶ www.news.mn

⁷ Chin Statistical Year book, 2017

⁸ CHYBook 2017

⁹ Poverty reduction and social transation. A.Battsetseg ,2019

илүүтэйгээр тухайн ядуу өрх, иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өөрсдийнх нь чадварыг дайчилж тогтмол ажилттай болгодог. Түүнчлэн Хятадад хөгжлөөрөө тэргүүлж буй бүсийнхэн нь баруун хойд хөгжөөгүй бүсээ тэтгэж, хүн ардаа туршлага солилцох замаар ядуурлыг бууруулж байна. Хятадын төрөөс халамжийн хавтгайруулсан тэтгэмж олгохоос илүү ядууралтай онцгой бүсүүдийг тогтоож, түүн рүүгээ чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, жишиг болгожээ.

Өнөөдрийн байдлаар Хятадын төрөөс хоёр хэлбэрийн халамж олгодог байна. Нэгд, тухайн муж, тосгонд тогтоосон өрхийн орлогын баталгаажсан төвшингөөс доогуур орлоготой байгаа өрхөд үлдэгдлийг нь нөхөн олгох тэтгэмжийг сар бүр олгодог байна. Тодруулбал, тухайн тосгоны баталгаажсан орлого 3000 юань бол сарын 2000 юанийн орлоготой өрхөд сард 1000 юанийг нэмж, тэтгэмж хэлбэрээр олгодог байна. Энэ төрлийн тэтгэмжийг сард ойролцоогоор 50 сая иргэнд олгодог аж. Хоёрт, 2011 оноос хойш 60-аас дээш насны тэтгэврийн насны ард иргэдэд сар бүр 80 юанийн тэтгэмжийг тэтгэвэр дээр нь нэмж олгодог болсон байна¹⁰

Дотооддоо болон дэлхийд нөлөө бүхий үйл ажиллагаа явуулдаг томоохон компани, группууд нь Хятадын төрийн зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу ядуурлыг бууруулах бодлогод чухал нөлөө үзүүлэн ажилладаг аж. Томоохон групп компаниуд бие даан муж, тосгоныг хамарсан ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлж байна. Нөгөө талаас өөрсдийнхөө нийгмийн хариуцлагын хүрээнд ядуурлыг бууруулах бодлогыг хөхиүлэн дэмжиж ажилладаг байна. Тухайлбал, GuiZhou мужийн LuYe FangTian 贵州绿野芳田 компанийн “Үйлдвэрлэл ба борлуулалтын нэгдмэл байдал” нь хөдөө аж үйлдвэрийн хувьслын чухал цөм бөгөөд үйлдвэрлэлийн амжилтыг ядуурлыг бууруулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Xixiu дүүрэгт хүнсний ногооны бүтээгдэхүүн их, чанар сайтай боловч урт хугацааны туршид фермерүүдийн үйлдвэрлэл, болоод борлуулалт сул, цар хүрээний тэлэлт багатай, орлогын өсөлт нь тодорхойгүй байсаар байсан харин хүнсний ногооны борлуулалтын асуудлыг шийдэхийн тулд Xixiu дүүргийн хүнсний ногооны нэр төрөл, брэнд нэрийн ногоо, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх тогтвортой байдлыг хангахын тулд олон хүний дэмжлэгтэйгээр 2017 оны 1-р сард GuiZhou мужийн LuYe FangTian компани байгуулагдсан байна. Мөн HuiShui тосгон дахь нүүлгэн шилжүүлэлтийн бүс болох Xinmin нийгэмлэг, GuiZhou мужийн Shenghua техник мэргэжлийн коллеж, GuiZhou мужийн Baishuihe Digital Town, Shuangbao балгасны DaBao тосгон, Anshun хот дахь XiXiu дүүргийн нүүлгэн суурьшсан Солонго цэцэрлэг зэрэг өөр өөрийн бүс нутгийн онцлог болон байгаль цаг уурын давтагдашгүй талуудаа гол болгож төрийн нэгдсэн бодлоготой уялдуулж ядуурлаас ангижирсан туршагууд их байна.

Интернет худалдаагаар алдартай BaiNiao компани, Taobao зэрэг нь хөдөө тосгонд газар тариалан, мал аж ахуйн эрхлэж байгаа иргэдийн бүтээгдэхүүнийг интернет орчинд сурталчилж, тариаланчид тариалангийн талбайгаас наймаа хийх,

¹⁰ A.Battsegseg, Diss 2019

үйлчлүүлэгчид эрүүл хүнсийг газар дээрээс нь илүү хямд өртгөөр худалдан авах боломжийг олгосоор байгаа нь нэг талдаа тариалан эрхэлж байгаа иргэдийн орлого, нөгөө талд интернэт компаниудын ашиг орлого ч нэмэгдэж байгаа тооцоо гарчээ. Мөн Хятадын томоохон барилгын компаниуд нь ядууралтай бүс нутгийг дахин төлөвлөх, нүүлгэн шилжүүлэх, орон сууцаар хангах цогц бодлогыг хэрэгжүүлж, нэгдсэн нэг бодлоготой ажиллаж байна.

Дүгнэлт: Өнөө үед БНХАУ хоолны мөнгөгүй байсан хүн амын давхрага бүрэн арилж алга болсон тухай илтгэж байна. Ядуурлыг устгах хөтөлбөр эерэг үр дүнд хүрсэн нь ядуус өөрсдөө түүнд идэвхтэй оролцдог явдалтай шууд холбоотой юм. Хятадын Коммунист нам нь ард түмэнтэйгээ харилцан итгэлцлийн харилцаа тогтоож чадсан нь харагдаж байгаа юм.

1.3 Хятад улсын ядуурлыг бууруулсан амжилт ба сорилтууд

70 аад оноос хойш өөрчлөн байгуулалт хийснээр БНХАУ ядуурлыг багасгах талаар маш их амжилт олсон бөгөөд орлого ба зарлагаар хэмжүүр хийж, ядуу хүний тоог их хэмжээгээр бууруулсан мөн ядуу иргэн болон өрх, ядуурал ихтэй бүс нутагт нийгмийн хөгжлийн өөрчлөлт маш их гарсан. 70 аад оноос хойш хэрэглэж байсан ядуурлыг бууруулах стратеги тактикийг өөрчлөн орчин үеийн нөхцөл байдал болон сорилтуудаас хамаарч БНХАУ ядууг бууруулах стратеги тактикаа өөрчлөх хэрэгтэй болсон юм. Юуны тэргүүнд даяарчлалын үед хот болон хөдөө тосгод нэгдэж байх цаг үед нийтийг хамруулсан нийгмийн хамгаалалт болон нийгмийн хөгжлийг хослуулсан стратеги бодлогыг төлөвлөж, хот хөдөөг ялгаварлалтай авч үзэх бодлогоос татгалзаж, олон талт бодлого хэрэгжүүлэх, ядуурлыг бууруулах арга замыг сонгох олон талын арга хэмжээ авах стратегийн хүрээг тогтоон ажиллаж байна.

Хот болон төвлөрсөн газарт ажлын байр олдохгүйгээс орлогын баталгаа үгүй болж үүнээс үүдсэн ядуурал газар авдаг бол хөдөөд ажиллах хүч үгүй болсоноос эзгүйдэл үүсч орлого бүр хумигдаж ядуурлыг улам гүнзгийрүүлдэг байна. Эдгээр нөхцөл байдал болон доорх учир шалтгаанууд Монгол Хятад 2 улсад одоо хир оршисоор байна. Жишээ нь:

1. Шилжилт хөдөлгөөний тухайд Шилжилт хөдөлгөөнд орсон ядуу иргэдэд үүсэх эрсдэл:

Ажлын байр тогтворгүй, хөдөлмөрийн ачаалал ихтэй, эрүүл мэндийн туслалцаа авах боломжгүй, эрүүл амьдрах баталгаа байхгүй, өвчний эрсдэлд: эрүүл ахуйн шаардлага хангаагүй сууцанд амьдрах, орлого бага, аюулгүй амьдрах орчин бүрдээгүй, нийгмийн гадуурхалд: хуулийн цоорхой ба холбогдох хууль дүрмийн дутагдалтай тал нь ядуу иргэдийг хамгаалж чадахгүйгээс үүдэн эдгээр хүмүүс нь гадуурхалд өртөх, үе дамжсан ядууралд өртөх, ядуурал архагших зэрэг аюултай.

Шилжилт хөдөлгөөнөөс үүссэн ядууралд авах арга хэмжээ: Нийгэм эдийн

засгийн боломж, нийгэм хамгаалал нь эмзэг иргэдийг ядуурлаас хамгаалах чухал арга бөгөөд үүний тулд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн давхраажилт, нийгмийн хамтын ажиллагааны боломжийг бүрдүүлж үндсэн чадварыг нь дэмжих хэрэгтэй.

БНХАУ хот хөдөөгийн эдийн засаг хөгжил ялгагдахаа больж хот хөдөөгийн ялгаа байхгүй болсоноор хөдөөгийн хүмүүс ядууралд өртөх эрсдэл нэмэгдсэнийг төр нь анзаарчээ, ингэснээр Хятадын засгийн газар ядуурлаас гаргах бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж ядуурлыг бууруулахын тулд ядуу иргэдэд зориулсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ авсан нь шилжилтээс үүссэн ядуурлыг бууруулж урт хугацааны болон богино хугацааны бодлогыг хослуулан системтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн.

Урт хугацааны бодлого: Ядуусыг нийгэмд идэвхитэй оролцоход чиглүүлсэн.

БНХАУ-н засгийн газар нь орлогын хуваарилалт дээр түшиглэж хүнийг хөгжүүлэх бодлогыг баримталж ядуурдыг бууруулах шинэ бодлого хэрэгжүүлэхээр болсон.

1. Макро түвшинд олон нийтэд зориулсан бодлого, татварын бодлого болон хууль эрх зүйн бодлогыг харилцан уялдуулж ядуу иргэд рүү чиглүүлсэн ба тэднийг боломжийн амьдруулах нөхцөл, өөрийгөө хөгжүүлэх эрхээр нь хангаж эхэлсэн.
2. Татварын хувьд ядуу өрхийн амьдралыг сайжруулахад зориулсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлж хөгжүүлэх талаас нь арга хэмжээ авч эхэлсэн.
3. Хууль эрх зүйн хувьд хөдөлмөр эрхлэгчдийн орлогыг баталгаажуулах, хуулиар хамгаалах арга хэмжээ авч эхэлсэн. Харин бодлогын талаас нь хүний нөөцийг хөгжүүлэх материаллаг баялаг болон байгалийн баялагийг ядуу иргэдэд зориулж зөв оновчтой ашиглуулах явдал юм.

Богино хугацааны бодлого: Ядуу хүнийг өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангах

Цаг агаартай хамааралтай ядуурал: Эрс тэс уур амьсгалтай газарт байгалийн гамшиг тохиолдох нь элбэг. Манай улсын хувьд зуд болох нь ядуурал үүсэх байгалийн шалтгаануудын нэг юм. Тиймээс эдгээр байгалийн хүчин зүйлээс хамааралтай үүсэх ядууралыг бууруулахын тулд шууд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй бөгөөд зөвхөн улс төрийн бодлогоор ядуурлыг бууруулана гэдэг нь өрөөсгөл ойлголт юм.

2. Олон улсын ядуурлаас гарсан туршлагаас

Олон улсын ядуурлаас гарсан туршлагаас харахад Герман улсад 19-р зууны 80-д онд төр засгаас ард иргэдээ хүчээр нийгмийн даатгал д хамруулах арга

хэмжээ авсан¹¹. Англи улсад нэгдсэн даатгалын системийг бий болгосон гэхдээ иргэд өөрийн сайн дураар даатгалд хамрагдах болсон. 1937 онд Англид худалдаа үйлдвэрийн салбарт ахмад настаны даатгал гаргасан. 1957 онд сайн дураар даатгалд хамрагдах иргэд нэмэгдсэн. АНУ 1935 онд нэгдсэн журмаар нийгмийн даатгалын дүрэм журам боловсруулсан. Япон дэлхийн 2 дайны дараа нийгмийн даатгалыг төр засгийн бодлогын хэмжээнд хөгжүүлсэн¹². 1945 онд японд онцгой байдалтай ядуу хүмүүст зориулж халамжлан амьдрах хөтөлбөрийг боловсруулсан. 1946 онд ажилгүйдэлийн даатгал болон ядуу хүний амьдралын баталгаат түвшини доод хэмжээг хангах хууль баталсан. 1948-1953 он хүртэл амьдралын баталгаа, ажилгүйдэл, үйлдвэрийн осол, тогтвортой ажиллах зэрэг талаар баталгаажуулах хуулийг боловсруулсан. 1957-1961 он хүртэл төр хүчээр бүх иргэддээ даатгалд хамрагдуулах бодлогыг хэрэгжүүлсэн. Өмнөд Солонгос 1920-д оноос хойш эдийн засаг хурдтай хөгжиж 1980 он хүрэхэд өмнө Солонгосын иргэд жаргалтай амьдрах, цалин их, нийгмийн хамгаалалд хамрагдах, орчин, эдийн засгийн талаар зөрчигдөж эрхээ эдлэх эрх олгосон¹³.

Үүний даараа бүх иргэддээ эрүүл мэндийн үйлчилгээ авах, тэтгэвэртэй болгох болон цалингийн доод түвшинг тодорхойлсон байна. Өмнөд Солонгос улс нь амьжиргааны доод түвшинг гурван төрлөөр тогтоосон. Амьд явах баталгаа, Амьдрах хамгийн доод түвшин, Амьдрах стандарт түвшин гэж 3 ангилсан. Нийгмийн хамгааллын хувьд нийгмийн халамжид амьдрах хамгийн доод түвшиний иргэд хамрагддаг¹⁴.

Олон улсын туршлагаас харахад хэсэгчилсэн систем нь нийгмийн далд эрсдэлийг дагуулж байдаг ба жишээ нь Улаанбаатар хотын хувьд дүүргээр тусгаарласан явдал гэж боддог. Тиймээс хэсэгчилсэн сүлжээнээс нэгдсэн сүлжээнд нэгдсэнээр бичиг баримтын зөрчлөөс үүдэн нийгмийн халамжид хамрагдах хүндрэл зэрэг далд хэлбэрийн эрсдэл үгүй болно гэж үзэж байна. Ажлын байр олох боломж ба ажлын байранд зориулж зээл олгох журмаар ажилын байрыг баталгаажуулах шилжилт хөдөлгөөнд орсон иргэдийг ядуурлын эрсдэлээс хамгаалах чухал аргачилал юм.

Мөн Энэтхэг улсад хот тэлэгдсэнээр Энэтхэг улсын олон иргэд хотруу нүүдэллэж эдийн засгийн боломжийг эрэлхийлсэнээс үүдэн хотод орон байрны хомсдол үүсэж ихэнх хүмүүс ядуусын хороололд амьдрах болсон төдийгүй засгийн газрын зүгээс шилжих хөдөлгөөнд оролцсон иргэдэд зориулж халамжийн сан бий болгосон. Ядуу хүнд зориулж баяжих хөтөлбөрийг хэрэгжүүлж ядуу хүнтэй гэрээ байгуулж хариуцлагыг дээшлүүлж хөдөлмөрийн хүчийг гадаадруу экспортлох арга хэмжээ хүртэл авсан байна¹⁵.

Мөн Кени улсын хувьд орлого багатай эмэгтэйчүүдэд жижиг хэмжээний зээл

¹¹ Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал. Я.Бямбасүрэн, 2012

¹² Guidelines for Constructing Consumption Aggregates for Welfare Analysis Deaton, A. and S. Zaidi, 2002

¹³ A. Battsegseg, Diss, 2019

¹⁴ Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал. Я.Бямбасүрэн, 2012

¹⁵ Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал. Я.Бямбасүрэн, 2012

олгодог бол Казастан улсын хувьд хувийн банкууд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор зээл олгодог гэх мэтээр ядууралтай тэмцэж байна.

2.1 Ядуурлын тухай ойлголтууд, хувьсал, хөгжлийн тухай

100 гаруй жилийн туршид дэлхийн олон судлаачид ядуурлын тухай ойлголтын талаар алхам алхамаар гүнзгийрүүлэн олон өнцгөөс нь судласаар байна. Энэтхэгийн эрдэмтэн Amartya.K.Sen¹⁶ шинэ санаа гаргасан нь судлаач нарын ядуурлын тухай судлагаа хийхэд онцгой ач холбогдол өгсөн. Энэ нь ядууст орлого оруулах чадавхын боложийг нь нээх өөрөөр хэлбэл хэвийн амьдрах чадамж дутагдсанаас ядуурах үндсэн шалтгаан болоод байна. Үүнээс гарах хамгийн энгийн арга бол хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх явдал юм хэмээсэн байна. Энэ талын судлагааг ихэнхдээ орлогын талаас нь судладаг байсан бол одоо чадавхын талаас нь судлах болсон нь ядуурлын онцлогийг бүхий л төлөөр нь дүгнэн, оновчтой санал дэвшүүлж тодорхойлоход бодит үр дүнтэй гэж үзсэн бөгөөд чадавхын талаарх ядуурлын тухай ойлголт илүү өргөн цар хүрээтэй болж, судлаачдын дэвшүүлж буй онол болоод санаа улам гүнзгийрч байна. Олон улсад ядуурлын мөн чанар болон ядууралд нөлөөлөх элементийг танин мэдэхийн тулд сүүлийн жилүүдэд маш их судлагаа хийгдэж байна. Жишээ нь: 90 ээд онд “Дэлхийн хөгжлийн тухай тайлан”-д ядуурлын уламжлалт ухагдахуун нь ихэнхдээ орлогын хомсдол талаас нь авч үздэг байсан бол сүүлийн үед хүний чадавхын талаас нь ихэвчлэн авч үздэг болсон хийгээд эрүүл мэнд, боловсрол, шим тэжээлт хоол хүнсний хэрэгцээ шаардлагыг эн тэргүүнд тавих болжээ¹⁷.

3. Монгол дахь ядуурал

Монголд өнөөг хүртэл халамжийг бодлого талаас нь сайн судласан, харин ядуу хүн, ядуу өрх талаас нь судлаагүй хэмээн эдийн засагч Я.Бямбасүрэн оновчтой дүгнэжээ¹⁸. Өрхийн ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд дээр дурдсан зүйл саад болж байсан. Нийгмийн халамжийн томоохон хөтөлбөр, тухайлбал Хүүхдийн мөнгө хөтөлбөр, алдарт эхийн урамшуулал, эхчүүдийн тэтгэмж зэрэг нь нэгэнт бодлогын өв болж тогтсон, хүн амын амьжиргаанд үзүүлэх тодорхой үр нөлөөтэй, гэр бүл болон төрөлтийг дэмжих агуулгатай тул шууд халахаас илүүтэй ядуу эмзэг бүлэгт нэмэгдүүлэх, хүүхдийн тооноос хамааран нэмэх зэргээр загварын хувьд өөрчлөх шаардлагатай. Өнгөрсөн 20 гаруй жил хот хөдөөгийн хөгжлийн тэгш бус байдал улам бүр газар авсан. Хөдөө орон нутагт ажиллаж, амьдрах боломж хомс байгаа нь амьдралын нөхцөл боломжоо дээшлүүлэх, мэдлэг боловсрол, мэргэжил эзэмшиж, амьдралын баталгаатай болохыг эрмэлзсэн хөдөөгийн ард түмний хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг эрс нэмэгдүүлсэн. Улмаар нийслэл хотод төвлөрсөн хүн амын нягтшил эрчимжиж, хотын зах хязгаар тэлсээр байгаа юм.

¹⁶ Amartya.K.Sen, 1981

¹⁷ Mongolia Poverty Assessment in a Transition Economy. Rural and SDOD China and Mongolia, 1996

¹⁸ Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал. Я.Бямбасүрэн, 2012

3.1 Монгол Улсын ядуурлын шалтгаан буюу түүний тархалт

Монгол Улсын нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, олон нийтийн тогтолцооноос хувийн хэвшлийн тогтолцоонд шилжин орсон улс төрийн нөхцөл байдалд Монгол Улсын иргэд ядууралтай нүүр тулж, нэн ялангуяа 1992-1998 оны хооронд хүн амын дундаж орлого 50 ам.доллар байсан бол 2010 он гэхэд өсч 300-500 ам.доллар болсон байна¹⁹. 2008 оны дэлхийн эдийн засаг хямарсан нь Монгол улсын хувьд ч хүндхэн нөхцөл байдалтай тулгарсан төдийгүй одоог хэр үргэлжилсээр байна.

Мөн өөрчлөлтийн үед зах зээлийн эдийн засаг, хувийн өмчийн тогтолцоо, үнийн хяналтгүй байдал, иргэдийн орлого зарлага тогтворгүй (Монгол Улсын хүн амын тоололгоор 2012 он) засгийн газар барааны үнэнд хяналт тавихгүй, зах зээлийн үнээс хамаарч үнэ хэлбэлзэж байсан шалтгаанууд байна. Засгийн газраас хөрөнгө оруулалтын хууль гаргаснаар гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, ажлын байр нэмэгдсэн хэдий ч Монгол иргэдийн цалин бага байсаар байсан. Учир шалтгаан нь дорвитой мэргэжилтэн дутмаг байсантай холбоотой мөн нийгмийн өөрчлөлтөөс хамаарч шилжих хөдөлгөөн ихээр явагдаж хөдөө нутгийн иргэд хот суурийн газарт Улаанбаатар хот болон аймгийн төвд амьдрахаар их нүүдэл үүссэний дотор 50% нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч төвлөрөл их үүсгэсэн нь ядуурлын бас нэг шалтгаан болж байна²⁰. Мөн төр засгийн уламжлалт бодлого алдагдсан, (4 жилд нэг удаа их хурал болон ерөнхийлөгчийг сонгодог) хөрөнгийн хуваарилалт жигд бус, зах зээлийн шударга өрсөлдөөн алдагдсан, үнийн зохицуулалт үгүй болж зохиомолоор инфляци үүсгэсэн, хөдөлмөр хамгааллын хууль болон нийгэм хамгаалалын дүрэм журамд учир дутагдалтай, хээл хахуул нэмэгдсэн зэрэг шалтгаануудыг тоочиж болох юм.

Сүүлийн үед өөрчлөн байгуулалт хийж байх эхэн үетэй харьцуулахад ядуурал буурч дунд давхаргын тоо нэмэгдсэн хэдий ч дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөлөл болон манай засгийн газрын улс төр эдийн засгийн уламжлалт бодлого алдагдсан, улсын санхүү багасах нь мөн л иргэдийн ахуй амьдралд нөлөөлж ядуурал нэмэгдэх дараагийн шалтгаан болсоор байна.

Монгол улсад ядуурлын түвшин 2011 оны байдлаар 29,8 хувьтай буюу 837,6 мянга орчим хүн ядууралд өртсөн байна гэсэн тооцоо бий²¹. Энэ бол Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн Банктай хамтран хийсэн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны 2011 оны үр дүн юм. Өөрөөр хэлбэл 100 Монгол хүн тутмын 30 нь ядуу байна гэсэн үг юм. Гэвч энэ нь 2010 оныхоос ядуурал 9,4 хувиар буурсан үзүүлэлт аж. Гэхдээ л манай улсын 837,6 мянган хүн наад захын хүнсний болоод хүнсний бус хэрэглээгээ худалдан авах чадваргүй байна гэсэн үг юм²². Харин 2018 оны тоон мэдээгээр Монгол улсын нийт хүн амын 28,9 хувь

¹⁹ ҮСГ, 2010.УБ хот

²⁰ ҮСГ, 2010.УБ хот

²¹ ҮСГ, 2014.УБ хот

²² ҮСГ, 2014.УБ хот

нь ядуу гэсэн тоон үзүүлэлтэй байна. Ядуурлын түвшинг газар нутгаар авч үзвэл нийслэл болон төвийн бүсүүдэд ядуурал харьцангуй бага буюу дөрвөн хүний нэг нь ядуу байна. Хангайн болон зүүн бүсэд ядуурал баруун бүсийнхээс өндөр, сумын төвүүд хөдөө орон нутгаас ядуурал багатай гарчээ²³. Улаанбаатар хотод нийт хүн амын 60 орчим хувь харин ядуу хүг амын дөрөвний нэг нь амьдарч байгаа ажээ. Хотод иргэдийн сарын дундаж хэрэглээ 174 мянган төгрөг байгаа бол хөдөөд 144 мянган төгрөг байна гэсэн дүр зураг гарчээ²⁴. Түүнчлэн улиралын байдал ядуурал ихээхэн хамаардаг байна. Жилийн 7-9, 10-12 сард хүн амын амьжиргаа сайжирч бусад үед нь мууддаг байна. Энэ нь эрс тэрс уур амьсгалтай манай орны хувьд харгалзан үзэх хүчин зүйл мөн юм. Эрүүл мэндийн зардалд ядуу бус хүмүүс ядуу хүмүүсээс 6,5 дахин илүү төлдөг бол боловсролын салбарт ч илүү их зарцуулдаг байна. Ядуу хүмүүсийн хэрэглээний дийлэнхийг хүнсний бараа эзэлдэг бөгөөд эргээд энэ төрлийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс хэрэглээ нь шууд хамаардаг байна. Хоёр хүртэл ам бүлтэй өрхүүд ядууралд өртөх нь харьцангуй бага байгаа бол дундаж буюу 3-5 ам бүлтэй өрхийн ядуучуудын 25,8 хувийг эзэлж байна. Энэ нь нийт хүн амын 70 орчим хувийг ядуучуудын 59,6 хувийг эзэлж буй үзүүлэлт юм. Харин наймаас дээш ам бүлтэй өрхийн 60,2 хувь нь ядуу байна. Энэ нь хүн амын тоо өсөх тусам ядууралд өртөх нь ихэсч байна гэсэн үг²⁵. Насны хувьд гучаас доош насанд ядууралд өртөх нь бага байснаа 30-39 насны бүлэгт ядуурал өсөж, дөч гарахаар буурч байгаа ажээ.

3.2 Ядуурлын түвшинг судлах дадал арга зүй ба Монголын ядуурлыг үнэлэх нь

Нийгмийн халамж хавтгайрсан, улсын болон орон нутгийн хэмжээнд улс төрийн нөлөөлөлд автах явдал түгээмэл, халамжийг хүргэх үйлчилгээний чанар муу, бусад байгууллагуудаас энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй уялдаа холбоо муутай, халамжийн зардал ихээр өсч байгаа боловч ядуурал тэр хэмжээгээр буурахгүй байгаа зэрэг нь нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх шаардлагатайг харуулж байна. Нийгмийн халамж хүртэхээс илүүтэйгээр хөдөлмөр эрхлэх сэдэлийг дэмжих, орон нутгийн түвшинд зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулах, удаан хугацаанд ажилгүйдлийн түвшин нь байнга өндөр байгаа газруудад төрийн шууд дэмжлэгтэйгээр хөдөлмөрийн оролцоо ихтэй үйлдвэрүүдийг байгуулах зэргээр цаашид нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх нь зүйтэй юм.

Ядуурлыг устгахад мөнгөний дүн хамаагүй бөгөөд галыг тосоор унтраахын адил бэлэн мөнгө тараах тусам ядуурал улам гаардагийг Америкийн ядуурлын эсрэг дайны туршлага харуулсан юм. Манай улсын хувьд ч ялгаагүй замбараагүй баахан тэтгэмж өгч (хүүхдийн мөнгө, жирэмсэн эхэд, оюутнуудад, залуу гэр бүлд гэх мэт) гал унтраах төдий ажил болж байсан. Статистикийн судалгаанаас үзэхэд

²³ УСГ, 2018 УБ хот

²⁴ УСГ, 2016 УБ хот

²⁵ News.mn. М.Жаргал, 2016

бэлэн мөнгө тараах арга хэмжээний ачаар зөвхөн тэтгэвэрийн насны хүмүүс л бодитоор ядуурлын зурааснаас дээгүүр гарч, бусад бүх категорийн хүмүүсийн ядуурлын түвшин улам дордсон байдаг. Ядуурлаас гарч чадсан ихэнх хүмүүсийн хувьд хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх нь л хамгийн үр нөлөө бүхий үзүүлэлт гэх дүгнэлтэнд хүрч байна.

3.3 Монгол улсын ядуурлыг бууруулах төрийн бодлого:

Төрийн болдогын оролцоо: Монгол Улсын хүн амын дундаж насжилт 60 гаруй бөгөөд ихэнх хүмүүс нь эдийн засгийн суурьгүй, өнөөгийн байдлаар Монгол Улсын засгийн газар шууд мөнгөн тэтгэмж олгох бодлогыг хэрэглэж байна. Монгол Улсын өнөөгийн дүр төрх, ядуу хүний онцлогийг харгалзан халамжийн тэтгэлэгээр хөрөнгөжүүлэх бодлогыг хувь хүний сэтгэлгээний ядуурлаас гарах бодлоготой хавсарч хэрэгжүүлвэл ядуурлаас гарах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Ядуурлаас гарах арга замыг судласны үндсэн дээр ядуу хүний хэрэгцээг зөв оновчтой шийдвэрлэж, засгийн газар, нийгэмлэг, аж хуйн нэгжтэй хамтарч халамжийн тэтгэлэгийг тэгшитгэж өгөх уламжилт арга барилаа өөрчилж, ядуучуудын онцлогт нийцүүлэн халамжийн бодлогонд өөрчлөлт оруулж, засгийн газар болон нийгмийн давхаргын оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Нөгөөтэйгүүр, хөдөлмөрийн хөлс бага байгаа учир залуучууд гадаадад “хар” ажил хийх гэж олноороо явж байна. Энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхээс өөр арга замгүй гэсэн үг юм. Хувийн хэвшилд үүнээс үүсэх дарамтыг арилгахын тулд компаниудыг аль болох олон татваруудаас чөлөөлж, тэд нараар уламжлан олон хүнийг ажилд оруулж, эдийн засгаа хөгжүүлэх нь чухал байна.

Ядуурал бол хувь хүний аж байдлын доройтол, гачигдалтай байдлаар илрэх бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавх доройтох, хоол тэжээлийн гачигдал, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байх зэргээр илэрдэг. Энэ бүгд нь тус бүрдээ аж байдлыг тодорхойлох бүрэлдэхүүн хэсгийг илэрхийлэх тул нэг бүрчлэн анхаарч судлах шаардлагатай бөгөөд бодлого боловсруулагч нарыг ядуурлын олон янзын хэлбэрт анхаарлаа хандуулахад тус болдог. Ядуурлын эдгээр ялгаатай бүрэлдэхүүн хэсгүүд хосолсон байх тохиолдол элбэг байдаг. Жишээлбэл, хоол тэжээлийн дутагдалд үргэлж орсон хүн голдуу боловсрол багатай, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй байх г.м. Орлого, хэрэглээ хоёрын алиныг нь аж байдлын хэмжүүр үзүүлэлт болгож сонгож авахыг шийдэх нь юуны түрүүнд чухал юм²⁶. Хэрэглээ нь амьжиргааны түвшнийг орлогоос арай нарийн хэмжиж тодорхойлдог илүү ач холбогдолтой буюу зохимжтой үзүүлэлт болно. Онолын

²⁶ А. Battsetseg, Diss 2019

хувьд ч мөн практик дээр ч амьжиргааны түвшинг хэрэглээгээр тодорхойлох нь орлогоор тодорхойсноос илүү зохимжтой, бодит байдлыг илэрхийлдэг гэж үздэг²⁷. Хэдийгээр энэ хоёр нь өөр ойлголтууд боловч хоёул сэтгэл ханамжийг ямар нэг байдлаар илэрхийлдгээрээ төстэй. Хэрэглээ нь хувь хүн бүр бодитоор юу хэрэглэснийг илэрхийлдэг бол орлого нь тухайн хүний чадварыг хөрөнгийн хамт хэмжинэ²⁸. Хүний бүхий л амьдралын туршид амьжиргааны түвшинг судлахыг сонирхож байгаа бол орлого ба хэрэглээний алийг нь сонгох нь ялгаагүй. Тухайлбал газар тариалан эрхэлж байгаа өрхийн орлогын түвшин нь ургац хураалт, тариалалтын үетэй холбоотойгоор маш хэлбэлзэлтэй байдаг учраас энэ үзүүлэлтийг ашигласнаар амьжиргааны түвшнийг үлэмж хэмжээгээр ихэсгэж, багасгаж бодит бусаар тооцоолох магадлал илүү байна.

ДҮГНЭЛТ

Шилжилтийн дараах орнуудын нэгэн адил Монгол Улсад хүн амын гуравны нэгээс илүү хувь нь ядуурлын нүхэнд унасан бөгөөд ядуурлын түвшин хорь гаруй жилийн туршид 30 хувиас буухгүй байсаар ирсэн. Шилжилтийн дараах улс орнуудтай харьцуулахад ядуурлын түвшин хэт өндөр байгаагүй ч, бусад орнуудаас удаан хугацаанд буурахгүй, үргэлжилж байснаараа онцлогтой байна. Монгол Улсын эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын гол төв болсон нийслэл хотод хүн ам олноороо төвлөрч, нягтрал бий болсноос үүдэн хөрсний бохирдол, агаарын чанарын бохирдол, хог хаягдал зэрэг хүмүүсийн амьдралын тав тухтай орчинд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг даруйхан шийдвэрлэх шаардлага нэн тулгамдаж байна. Мөн Улаанбаатар хот орчимд амьдарч буй ядуу өрхийн хүүхдүүдийн нийтийн тээвэр, сургуулийн зардал, эмнэлгийн үйлчилгээ гэх мэт шууд хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг бий болгох хэрэгцээ хойшлуулшгүй чухал байна.

Ядуу өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндэд хөрөнгө оруулах нь ядуусын амьжиргааны түвшинг сайжруулах чухал алхам бөгөөд шилжин ирэгчид болон ядуусын эрхийг хамгаалах, нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийг хүн амд хавтгайруулах бус зорилтот бүлэгт чиглүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэх сургалтад хамруулах, зуучлах, орлогыг нэмэгдүүлэх, улмаар ядуурлаас сэргийлэхэд чиглэсэн бодлогын цогц арга хэмжээг авах шаардлагатай байсаар байна.

Харин Хятад улсын хувьд туршлага болохуйц хэд хэдэн жишээ дурдахад: Хятад улс дотооддоо болон дэлхийд нөлөө бүхий үйл ажиллагаа явуулдаг томоохон компани, группуд нь Хятадын төрийн зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу ядуурлыг бууруулах бодлогод чухал нөлөө үзүүлэн ажиллаж байна. Томоохон групп компаниуд бие даан муж, тосгоныг хамарсан ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх ба нөгөө талаас өөрсдийнхөө нийгмийн хариуцлагын хүрээнд

²⁷ Монгол улс оролцооны аргаар ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх нь. АХБ, 2006

²⁸ A.Battsetseg. Diss, 2019

ядуурлыг бууруулах бодлогыг хөхиүлэн дэмжиж ажиллаж байна. Тухайлбал, Интернет худалдаагаар бүх компани хөдөө тосгонд газар тариалан, мал аж ахуйн эрхлэж байгаа иргэдийн бүтээгдэхүүнийг интернет орчинд шууд сурталчилж, тариаланчид тариалангийн талбайгаас наймаа хийх, үйлчлүүлэгчид эрүүл хүнсийг газар дээрээс нь илүү хямд өртгөөр худалдан авах боломжийг олгожээ. Ингэснээр нэг талдаа тариалан эрхэлж байгаа иргэдийн орлого, нөгөө талд интернэт худалдааны компанийн ашиг орлого ч нэмэгдэж байна.

Мөн Хятадын томоохон барилгын компаниуд нь ядууралтай бүс нутгийг дахин төлөвлөх, орон сууцаар хангах цогц бодлогыг хэрэгжүүлж, нэгдсэн нэг бодлоготой ажиллаж байгааг AnShun хотын XiXiu дүүргийн Солонго хороолол цэцэрлэг сургуулиудын жишээ харууллаа. Үүгээр зогсохгүй орон нутагт иргэдэд газар эзэмшүүлэх замаар хөдөө аж ахуй газар тариаланг дэмжиж, ядуурал ажилгүйдлийг бууруулах бодлого хэрэгжүүлсэн нь ядуурлыг богино хугацаанд их тоогоор гаргасан амжилт олсон. Ингэснээр ард иргэд нь эзэмшлийн газартаа газар тариалалт болон мал аж ахуй хөгжүүлж, гар урлал, хатгамал зэрэг жижиг үйлдвэрлэлээрээ тогтмол орлогын эх үүсвэртэй болж байна. Мөн хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авч хотжилтын ядуурлаас сэргийлж чадсан, хавтгайрсан нийгмийн халамжаас зайлсхийж ядуу өрх, иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өөрсдийнх нь чадварыг дайчилж тогтмол ажилтай болгосон, орлогын эх үүсвэрийг дэмжих үүднээс гурван жилийн хугацаатай 50 мянган юанийн зээлийг ямар ч хүүгүй олгосон зэрэг шууд ядуу хүн болон ядуу өрхөд нөлөөлж ядуурлаас гарч буй туршлага олон байна.

НОМ ЗҮЙ

- Battsetseg, 2019, Poverty reduction and social transation. Dissertation. 2019
Mongolia Poverty Assessment in a Transition Economy. Rural and SDOD
China and Mongolia, 1996
- Deaton, A. (1997). The Analysis of Household Surveys: A Microeconomic
Approach to Development Policy. Baltimore, the John Hopkins University
Press.
- Deaton, A. and S. Zaidi (2002). "Guidelines for Constructing Consumption
Aggregates for Welfare Analysis." LSMS Working Paper 135, World
Bank, Washington, DC.
- National Statistical Office, NSO (2009). "Poverty Profile in Mongolia: Main
Report of Household Socio-Economic Survey 2007-2008," Ulanbaatar,
Mongolia.
- Ravallion, M. (1998). "Poverty Lines in Theory and Practice." Living Standards
Measurement Study Working Paper 133, World Bank, Washington, DC.
- Ravallion, M. (1992). "Poverty Comparisons: A Guide to Concepts and
Methods." Living Standards Measurement Study Working Paper 88,
World Bank, Washington, DC.
- Ravallion, M. and S. Chen (1996). "What Can New Survey Data Tell Us about
Recent Changes in Distribution and Poverty?" Policy Research Working
Paper 1694, World Bank, Washington, DC.

- World Bank (2009). "Mongolia Monthly Economic Update: November 2009."
World Bank, Washington, DC.
- Townsend Peter. Poverty in the United Kingdom: A Survey of Household
Resources and Standards of Living M. Berkeley: University of California
Press, 1979:53.
- Townsend Peter. A Sociological Approach to the Measurement of Poverty: A
Rejoinder to Professor of Amartya Sen J. Oxford Economic Paper, 1985,
37(4):659-668.
- Martin Ravallion. Poverty Lines in Theory and Practice M. LSMS Working
Paper NO. 133, World Bank Publications, 1998: 8-9.
- Scitovsky Tibor. The Joyless Economy M. Oxford: Oxford University Press.
1978: 24.
- Understanding social problems. (2011). Belmont: Wadsworth learning.
- UNDP. (1994). The national poverty alleviation programme. Mongolia.
Ulaanbaatar: Government of Mongolia.
- Deaton, A. and S. Zaidi, 2002
Guidelines for Constructing Consumption Aggregates for Welfare Analysis
Amartya.K.Sen, 1981 Poverty and famines an essay on entitlement and
deprivation.
- UNDP. (2003). Millennium Development Goals Report'. Retrieved from
Ulaanbaatar:
- UNDP. (2004). Mongolian National Human Development Report for 2003.
Retrieved from Ulaanbaatar:
- UNDP, & NSO. (2009). Methodology for calculating Mongolia's Millennium
Development Goals Indicators. Retrieved from Ulaanbaatar:
- UNDP, & NUM. (2004). Urban poverty in Ulaanbaatar and migration.
Retrieved from Ulaanbaatar:
- Wu, F., Zhang, F., & Webster, C. (2013). Informality and the development and
demolition of urban villages in the Chinese peri-urban area. Urban Studies,
50(10), 1919-1934.
- Xue, J., & Zhong, W. (2003). Unemployment, poverty and income disparity in
urban China. Asian Economic Journal, 17(4), 383-405.
- Yang, D. T. (1999). Urban-biased policies and rising income inequality in
China. American Economic Review, 89(2), 306-310.
- Бойроу.Ж. (2009). Ололтуудыг бататган, өсөлт уналтыг удирдаж,
үйлчилгээг илүү сайн хүргэх нь, Төсвийн удирдлага, санхүүгийн
удирдлагын тойм судалгаа. Retrieved from Вашингтон:
- China Statistical Year book, 2017
- Дагвадорж.Ч. (2004). Нийгмийн хамгаалал, онол арга зүй, туршлага,
харьцуулалт. Улаанбаатар: Хөх судар хэвлэл.
- . Засгийн газрын мэдээ. (1993), 6.
- МЗХ. (2006). Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн
байдал. Үндэсний илтгэл.
- Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар.
(2005). Retrieved from Улаанбаатар:
- Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар
судалгааны тайлангаас. (2006). Retrieved from
- Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр
дагавар судалгааны тайлан. (2008). Retrieved from Ulaanbaatar:
- НАМЗХ. (1993). Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь
судалгааны урьдчилсан тайлан Retrieved from

- НАМЗХ. (2013). Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь судалгааны урьдчилсан тайлан Retrieved from
- НЗДТГ. (2014). Хүн амын амьжиргаа. Retrieved from
- Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ. (2015). Retrieved from Улаанбаатар:
- НҮБХХ, & МУЗГ. (1994). Хөгжлийн хөтөлбөрт ядуурлыг бууруулах асуудлыг тусгах” сэдэвт үндэсний семинарын материал. Retrieved from Улаанбаатар:
- . Өмч хувьчлалын явц, өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай: УИХ. ын тогтоол. (1995). Засгийн газрын мэдээ.
- УИХТГ. (2015). Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040 төсөл. Retrieved from Улаанбаатар:
- ХАХНХЯ. (2012-2016). ХАХНХЯ-ны тайлан. Retrieved from Улаанбаатар:
- ШУА. (2014). Монгол дахь хотжилт:үйл явц ба төлөв байдал. Retrieved from Улаанбаатар
- Я.Бямбасүрэн, 2012. Ядуурлыг бууруулах төрийн бодлогын зарим асуудал.